



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

Г Т
Хорооны 2008 оны 78, 191, 2012 оны 248 дугаар
тогтоолоор батлагдсан журмуудад зарим
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-д дор дурдсан агуулга бүхий 5.6 дахь хэсгийн заалтыг нэмсүгэй.

1/ 5.6 дахь хэсгийн заалт:

“Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ нь 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, сүүлийн 4 улирал дараалан ашигтай ажилласан байна” .

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-ын 5.2 дахь хэсгийн заалтын “...нэгээс дээш жил ...” гэснийг “... 6 сараас дээш ...” гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 6.2 дахь хэсгийн заалтын “... хувьцаат капиталд ...” гэснийг “... өөрийн хөрөнгөд...” гэж, мөн журмын 10.1.9 дэх хэсгийн заалтын “... хувьцаат капиталын ...” гэснийг “... өөрийн хөрөнгийн ...” гэж тус тус өөрчилсүгэй.


3. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг

тооцож, хяналт тавих журам"-ын есдүгээр хавсралтыг энэ тогтоолын хавсралтаар өөрчилсүгэй.

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-ын 2.6 дахь хэсгийг хассугай.

5. Журмуудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 346 дугаар тогтоолын хавсралт

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 9
УХА0410 5043239

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

20 оны ...-р улирал

/мянган төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ДҮН
А	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
1	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө		
2	2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө		
Б	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ		
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг		
В	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА (Б/А*80%)	****	
Г	БАЙВАЛ ЗОХИХ / 80 ХУВИАС ИХГҮЙ/	****	80.00%
Д	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/	****	
Е	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,8-А)	****	

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР